



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/387

Хэрлэн сум

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорьдугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 49,600,000 төгрөгийн балансын үнэтэй, 49,600,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үлдэх өртөггүй 43-80ХЭУ улсын дугаартай ЖАК маркын автомашиныг анхны дуудлага худалдааны үнэ 2,500,000 төгрөгөөс 50 хувиар үнэ бууруулж 1,250,000 төгрөгөөр худалдахыг баталсугай.

2.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Г.Лхагвахатан - Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч: Б.Должинсүрэн – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн


Тэмдэглэл

хөтлөгч: Л.Отгончимэг - Орон нутгийн өмчийн газрын хуулийн зөвлөх

3.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулсугай.

4.Эд хөрөнгийн дуудлага худалдаа хийх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ